

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Хорих ял эдлүүлэх ажиллагаа

JUVENILE JUSTICE SYSTEM (НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНИЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО) ТУХАЙ

ABOUT THE JUVENILE JUSTICE SYSTEM



Б.Галбадрах

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн

Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн профессор, доктор (Ph.D), дэд профессор, дэд хурандаа

Товч утга: Өгүүлэлд гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүний хэргийг шүүн хэлэлцэх, эрүүгийн ял эдлүүлэх, нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх тогтолцоо буюу “Juvenile Justice”-ийн талаар судлан үзсэн.

Түлхүүр үгс: эрүүгийн бодлого, насанд хүрээгүй хүн, нөлөөллийн арга хэмжээ.

Abstract: The article examines the system of adjudicating cases of juveniles who have committed crimes, serving criminal sentences, and implementing impact measures, or "Juvenile Justice."

Keywords: criminal policy, juveniles, and impact measures.

Арван найман насанд хүрээгүй хүмүүст эрүүгийн, эрүүгийн ял эдлүүлэх бодлогыг тусгайлан авч үзэх нь насанд хүрээгүй гэдэг статус болон эдгээр бүлгийн хүмүүсийн нийгмийн үр дагаврыг харгалзан үздэгтэй холбоотой. Гэмт явдал нь нийгмийн үйлдвэрлэлийн нөөц боловсон хүчин, улс орны ирээдүйн сайн сайхан, аюулгүй байдлын баталгаа болж, үнэт зүйлийг хадгалж явах учиртай залуу үеийг ёс суртахууны хувьд тахир дутуу болгодог. Энэ үүднээс энэ бүлгийн хүмүүст үйлчлэх эрүүгийн, эрүүгийн ял эдлүүлэх бодлого нь чухал ач холбогдолтой.

Насанд хүрээгүй хүмүүсийн чиглэлээр эрүүгийн, ял эдлүүлэх бодлого нь улс орны нийгмийн бодлогын салшгүй хэсэг болон хэрэгждэг ба улс орны нийгэм, эдийн засгийн байдлаас шалтгаалан өөрчлөгдөж байдаг. Насанд хүрээгүй хүнд оногдуулж байгаа хамгийн хатуу ялын төрлийг судлан үзэхэд Исламын Бүгд Найрамдах Иран Улсад гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд цаазаар авах

ялыг оногдуулсаар байна. Саудын Арабын Хаант Улсад 2020 он хүртэл цаазаар авах ялыг насанд хүрээгүй хүнд оногдуулж байсан байна. ЗХУ-д мөн 1935-1947, 1950-1959 онуудад үйлчилж байсан эрх зүйн хэм хэмжээний хүрээнд 12 насанд хүрсэн хүнд цаазаар авах ялыг оногдуулах зохицуулалт байсан хэдий маш ховор хэрэглэсэн байдаг байна. Харин АНУ-д 1989 он хүртэл 16-аас доош, 2005 он хүртэл 18-аас доош насны хүнд цаазаар авах ял оногдуулдаг байсан бөгөөд тус улсын Дээд шүүхээс энэ хэм хэмжээг хүчингүй болгосон байна.

Харин өнөө цагт бараг бүхий л соёл иргэншсэн улс орнууд “нөхөн сэргээх шударга ёс”-ны зарчимд чиглэх ханддагтай байгаа бөгөөд гол зорилго нь хохирогчийн хохирлыг барагдуулах төдийгүй гэмт хэрэгтнийг нөхөн сэргээх замаар өөрийн сөрөг зан үйлийг үл зөвшөөрч ойлгуулах, нийгэмд эргэн нэгтгэхэд оршиж байна. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнийг гэмт хэрэгтэн, хэлмэгдүүлэх объект гэж үздэггүй, харин голчлон асуудалд орсон хүүхэд гэж үздэг. Мөн энэ тохиолдолд шударга ёс нь ял шийтгэл бус, харин тэдний амьдралын нөхцөл, хүмүүжлийн арга хэмжээ, нийгэмшүүлэхэд чиглэсэн байдаг. Үүний гол үзэл санаа нь нийгмийн шударга ёсыг тогтоохоос гадна хүүхдийг нийгмийн бүрэн эрхт гишүүн хэвээр хадгалах, түүнийг гадуурхахаас сэргийлэх явдал юм. Хорих байгууллагууд, ялангуяа насанд хүрээгүй хүмүүсийн хувьд дахин гэмт хэрэг үйлдэх, тэдний нийгэмд дасан зохицох чадварыг үгүй болгодог гэж үздэг байна.

Дэлхийн нийтийн хэмжээнд хууль тогтоогчид, судлаачдын анхаарлын төвд оршидог чухал судлагдахуун нь насанд хүрээгүй хүний эрх зүйн тогтолцоо юм. Juvenile justice – (латин хэлнээс juvenalis – хүүхдийн, Justitia – шударга ёсыг тогтоох гэсэн утгатай) насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн хууль зөрчсөн үйлдлийг шүүн таслах, тэдний эрхийг хамгаалах үйл явц юм.

1870-аад оны эхээр АНУ-ын Бостон хотын иргэд болох Күүк, Аугустус нар засарч хүмүүжих боломжой насанд хүрээгүй хүмүүст ял оногдуулахгүйгээр, асран хамгаалах, хяналтын чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх талаар шүүгчдэд санал болгож эхэлсэн байдаг. 1899 оны 7 дугаар сард АНУ-ын Чикаго хотод Иллинойс мужийн “Хаягдсан, хараа хяналтгүй, гэмт хэрэгт холбогдсон хүүхдүүд, тэдэнд хяналт тавих тухай” хуульд үндэслэн насанд хүрээгүйчүүдийн анхны шүүх байгуулагджээ. Уг хуулийг батлах, насанд хүрээгүйчүүдийн шүүх байгуулах ажлыг Чикагогийн эмэгтэйчүүдийн клубын гишүүн Люси Флоуэр, “Халл Хаус” олон нийтийн байгууллагын гишүүн Жулиа Латроп, Visitation and Aid нийгэмлэгээс санаачилсан байдаг. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хэлэлцэхийн тулд “гэмт хэрэгтэн” (англ. criminal) гэсэн ойлголтоос ялгаатай “гэм буруутан”, “хууль зөрчигч” (англ. delinquent) гэсэн шинэ ойлголтуудыг гаргаж, насанд хүрээгүй хууль зөрчигчдийг насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн субъектийн статустай болгосон байна.

Хожим Их Британид насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн үзэл санааг хөгжүүлж, 1908 онд насанд хүрээгүй хүмүүсийн тухай хэд хэдэн хууль батлагдсан байдаг. Франц Улсад 1914 онд АНУ-ын туршлага дээр үндэслэн насанд хүрээгүйчүүдийн шүүхийг байгуулжээ. Улмаар Их Британий шүүхүүд насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд хариуцлага хүлээлгэхдээ сануулга өгөх, хүмүүжлийн нөлөө үзүүлэх ярилцлага, хөдөлгөөнд хязгаарлалт тогтоохоос эхлээд нийтэд тустай ажил, хорих ялыг оногдуулдаг байна.

Өнөөдрийн байдлаар дэлхийд насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн хэд хэдэн загвар бий болсон байна. Тухайлбал, Англи-америкийн, Эх газрын, Скандинавын зэрэг. Зарим орнуудад гэр бүл, хүүхдийн эрхийн асуудал эрхэлсэн төрийн, төрийн бус байгууллагууд насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн хэсэг болсон байдаг.

Их Британи, АНУ-д өсвөр насны хүнийг хүнд байдалд оруулахгүй байх зарчмаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийг эрмэлздэг байна. Жишээ нь боловсролын түвшнийг дээшлүүлэх, шинэ мэдлэг, ур чадвал, дадлыг төлөвшүүлэх, мэргэжлээ сонгоход туслах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг.

Эх газрын загвар (Франц, Канад) нь өсвөр насны хүн хууль сахиулагчийн анхааралд өртсөн эхний тохиолдлоос л түүний хэргийг нэг шүүгч л хэлэлцдэг бөгөөд ингэснээр тухайн өсвөр насны хүний амьдралын байдлыг сайн мэдэж, шударга ёсыг хангуулах чиг үүргийг нийгмийн хамгаалалтай уялдуулан хэрэгжүүлдэг байна.

Скандинавын загвараар (Швед, Финланд) 15 хүртэлх насны хүмүүст эрүүгийн хариуцлага хүлээлгэдэггүй бөгөөд 15-18 насны хүмүүсийн хэргийг энгийн шүүхээр хэлэлцэж насанд хүрсэн хүмүүсээс зөөлнөөр шийтгэдэг. Насанд хүрэх хүртэл хорих байгууллагад хорьдоггүй ба тусгай засан хүмүүжүүлэх байруудад байлгадаг байна.

Эдгээр загварууд нь гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, түүнд хүмүүжлийн нөлөө үзүүлэх арга хэмжээг авдаг байна. Манай улсын хувьд тусгайлсан насанд хүрээгүй хүний хэргийг шүүн хэлэлцэх шүүхийн тогтолцоо бүрэлдээгүй хэдий ч Скандинавын загвартай нийцсэн зохицуулалт Эрүүгийн хуульд байдаг. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно буюу насанд хүрсэн хүнээс 2 дахин бага байхаар тогтоосон байдаг. Мөн хуулийн 8.4 дүгээр зүйлд шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангид зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд тус хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан зорчих

эрхийг хязгаарлах ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасган; 8.5 дугаар зүйлд шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд тус хуулийн 5.6 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан хорих ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана гэж¹ тус тус заасан байна.

Насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн тогтолцоо (англ. juvenile justice system) нь насанд хүрээгүй хүмүүстэй харьцах харилцааг зохицуулах хууль тогтоомжийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг насанд хүрээгүй хууль зөрчигчтэй ажилладаг байгууллага, байгууллагуудын нэгдсэн сүлжээ байгууллага болоод байгаа юм. Эдгээр байгууллагуудад цагдаа, шүүх, прокурор, хорих байгууллага, пробацын алба, насанд хүрээгүйчүүдийн засан хүмүүжүүлэх байгууллагууд багтдаг. Ийм тогтолцооны тод жишээ бол АНУ-ын насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн тогтолцоо юм.

Энэ тогтолцоо манай улсад байгааг мөн үгүйсгэж болохгүй бөгөөд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт хүүхдийн тусгай хамгаалалтаар хангах арга хэмжээг цагдаагийн алба хаагч, сум, баг, хорооны Засаг дарга, харьяа сум, баг, хороо, сургуулийн нийгмийн ажилтан, эсхүл хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа ажилтантай хамтран хэрэгжүүлнэ гэж заасныг дурдах нь зүйтэй. Харин пробацын албаны тухайд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Ял шийтгэгдсэн хүнийг нийгэмшүүлэх, суллагдахад бэлтгэх, нийгмээс тусгаарлахгүйгээр ялын бодлогыг хангах зорилгоор “Цахим хяналтыг төв”-ийг байгуулж, пробацийн тогтолцоог хөгжүүлнэ”² гэж заасан байгаа нь гэмт хэрэг үйлдсэн, хохирогч болсон насанд хүрээгүй хүнтэй ажиллах бүрэн хэмжээний тогтолцоог бий болгоход ойрхон байгааг тэмдэглэх хэрэгтэй.

Насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн тогтолцооны гол элемент нь насанд хүрээгүйчүүдийн шүүх бөгөөд өөрийн эрх хэмжээний хүрээнд талуудын аль нэг нь насанд хүрээгүй хүний эрүү, иргэн, захиргааны хэргийг хянан хэлэлцдэг. Насанд хүрээгүйчүүдийн шүүхийн үндсэн чиг үүрэг бол хүүхдийг хамгаалах, тэднийг нөхөн сэргээх юм. Гэмт хэргийн хувьд бүх зүйл тодорхой бөгөөд тодорхой хууль зөрчсөн үйлдэл байгаа бол ямар нэгэн хариуцлага байх ёстой бөгөөд зөвхөн ял нь хэр хатуу байх талаар л үзэл санаа байдаг. Насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн өөр нэг салбар байдаг нь хүүхдийн эрхийг хамгаалах юм. Гол шийдвэрлэх асуудал нь “хүмүүжүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй” байдаг байна. Хүүхэд гэр бүлийн хүрээнд ямар нэгэн хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хууль сахиулах байгууллага, халамж, хүүхэд хамгааллын байгууллагын зүгээс

¹ Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. №07.

² “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого // Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол.

эцэг, эхэд нь хариуцлага хүлээлгэж хүүхдийг хамгаалалтад авах хүртэл арга хэмжээг авдаг байна.

Хэрэв шууд аюул занал байхгүй хэдий ч буруу хүмүүжүүлсэн тохиолдол бий болвол (хүүхэд гэмт хэрэг үйлдсэн, сургуульд сурдаггүй, зохимжгүй хувцасласан, биед нь хүчирхийллийн шинж тэмдэг бий болсон гэх мэт) хүүхдийн талаар авах арга хэмжээний үйл явц илүү өргөн болдог. Учир нь юун түрүүнд халамжийн байгууллага хүүхэд хүчирхийллийн хохирогч болсон эсэхийг тогтоодог. Хэрэв хүчирхийллийн хохирогч болсон нь тогтоогдвол тусгай комисс хүүхдийн аюултай нөхцөл байдалд байгаа, төрийн хамгаалалтад авах шаардлагатай гэж үзэж болдог. Энэ тохиолдолд хүүхдийг эцэг эхээс нь түр хугацаагаар (зургаан сар хүртэл) эсвэл бүрмөсөн авч болдог ба өөрөөр хэлбэл эцэг эх байх эрхийг хасах хүртэл арга хэмжээ авч болдог байна.

Эцэг эх байх эрхийг нь хасах арга хэмжээ нь хамгийн эцсийн арга хэмжээ бөгөөд түгээмэл хэрэглэгддэггүй. Асран хамгаалах, халамжийн байгууллагын ажилчид хүнд нөхцөлд байгаа гэр бүлийг тогтмол эргэж тойрч, хяналт тавьдаг бөгөөд хүүхдийг нь эцэг эхээс нь салгахыг төдийлөн эрмэлздэггүй. Учир нь тийм ч сайн биш гэр бүлд өсөх нь асрамжийн газарт өссөнөөс дээр гэж үздэг байна.

Үүнтэй төстэй ажлыг ч манай улсад хэрэгжүүлэх зохицуулалт бий. Тухайлбал, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт эрсдэлт нөхцөлд байгаа, гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг нийгэмд хэвийн амьдрахад нь тусалж, дэмжих чиглэлээр мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах; нөхцөл байдлын үнэлгээ хийх; аюулгүй байдлагын үнэлгээ хийх; аюулгүй байдлыг хангах; дэмжих, холбон зуучлах; хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх зэрэг хариу үйлчилгээ үзүүлнэ¹ гэсэн байдаг. Хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах зохицуулалт ч манай улсад байдаг бөгөөд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 30 дугаар зүйлд хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээлэл хүлээн авсан цагдаагийн байгууллага, сум, баг, хорооны Засаг дарга хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн хамгаалах зорилгоор хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх; өмнөх арга хэмжээг авах боломжгүй бол эцэг, эх, төрөл, садангийн болон бусад этгээд, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх; хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх; хүүхдийн ажилтанд мэдээлэх зэрэг арга хэмжээг² авахаар заасан байна. Үүнээс гадна хүүхдийг хүчирхийлэл үйлдэгчээс тусгаарлах арга хэмжээ авсан нь эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэл

¹ Хүүхэд хамгааллын тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2024. №30.

² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №5.

болохгүй бөгөөд гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй байх бөгөөд сайн дурын сургалтыг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно, зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна гэж заасан байдаг.

Насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн тогтолцооны хүрээнд бусад асуудлуудыг ч хөнддөг. Гэр бүл нь асран хамгаалах, халамжийн байгууллагын анхааралд хэдийнээ орсон байсан ч хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчийнхаа гэмт хэргийн хохирогч болдог. Энэ тохиолдолд ажилчдыг ажилдаа хайхрамжгүй хамдсан гэж арга хэмжээг авдаг байна. Гэвч хүүхдүүдийг гэр бүлээс нь салгах асуудалыг маргаантайгаар шийдвэрлэх нь асуудал үүсгэдэг.

Жишээ нь Европын насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн тогтолцоонд зарим ойлгомжгүй зүйлүүд байдгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэсэн байдаг. Жишээ нь Финланд Улсад хүүхдийг бурханд итгэсэн, цамцаар цохисон нь, эсвэл чихэр өгдөггүйнх нь төлөө эцэг эхээс нь салгасан тохиолдлууд байдаг. Харин тус улсын иргэд, эрх бүхий байгууллагаас хүүхдийг эцэг эхээс нь салгах зохистой үндэслэл байх хэрэгтэй гэж үзсэн байдаг.

Насанд хүрээгүй хүний эрх зүйн сайн тогтолцоо нь төрд асар их ашиг тусаа өгдөг гэж тэмдэглсэн байдаг. Тухайн тогтолцоог нэвтрүүлсэн тохиолдолд, гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүнд хорих ял оногдуулах хувь маш бага буюу нийт оногдуулж байгаа ялын 5 орчим хувийг эзэлдэг байна. Мэдээж энэ тохиолдолд татвар төлөгчийн төлсөн мөнгөний асуудал яригдах учир эмнэлгийн байгууллагаар жишихэд хэвтэн эмчлүүлэхээс амбулаторын эмчилгээ хийлгэх нь гарах зардал 4-5 хувь бага байдаг байна¹.

Насанд хүрээгүй хүний үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн тухай бие даасан хуулийг ХБНГУ, БНФУ, Их Британи, БНЭУ, Япон Улс, Канад Улс, АНУ зэрэгт хэрэгжүүлдэг бөгөөд тухайн хуулиар гэмт хэрэг хүлээлгэх насны хязгаар, хүлээлгэх хариуцлага, хүмүүжлийн нөлөө үзүүлэх арга хэмжээнүүдийн талаар тусгасан байдаг бөгөөд өөр өөрийн гэсэн давуу тал, онцлогуудтай байдаг.

Дээрхээс дүгнэхэд дэлхийн олон орнуудад нэвтрээд буй насанд хүрээгүй хүмүүсийн эрх зүйн тогтолцооны хүрээнд бий болсон эрх зүйн зохицуулалтууд Монгол Улсын хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Тухайлбал, гэмт хэрэг

¹https://secretmag.ru/enciklopediya/chto-takoe-yuvenalnaya-yusticiya.htm#%D0%98%D1%81%D1%82%D0%BE%D1%80%D0%B8%D1%8F_%D1%80%D0%B0%D0%B7%D0%B2%D0%B8%D1%82%D0%B8%D1%8F_%D1%8E%D0%B2%D0%B5%D0%BD%D0%B0%D0%BB%D1%8C%D0%BD%D0%BE%D0%B9_%D1%8E%D1%81%D1%82%D0%B8%D1%86%D0%B8%D0%B8 (2024.10.01)

үйлдсэн хүнд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ялыг хоёр дахин багасгаж оногдуулах, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах ажлыг хэрэгжүүлдэг байна. Харин гэмт хэрэг үйлдсэн хүний хэргийг хэлэлцэх, бие даасан хууль хараахан байхгүй байна.

Эх сурвалж

Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016. №07.

Хүүхэд хамгааллын тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2024. №30.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль // Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017. №5.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого // Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоол.

<https://secretmag.ru/enciklopediya>

---o0o---

МОНГОЛ УЛС ДАХЬ ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЧИГ ХАНДЛАГА

CHANGES AND TRENDS IN THE EXERCISE OF PRISON IN MONGOLIA



И.Санчиргарав

*Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр
Гүйцэтгэлийн албаны сургуулийн Аюулгүй байдлын
тэнхимийн багш, хууль зүйн магистр, хошууч*

Хураангуй: Монгол Улс дахь хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын түүхэн уламжлал түүний дотор хоригдлыг хөдөлмөрлүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, нийгэмшүүлэх ажил, түүний хэлбэр, зохион байгуулалт, хорих анги дахь сургалт, сургалтын хэлбэр зэргийг холбогдох хууль тогтоомжид хэрхэн тусгалаа олж, үр дүнгээ хэрхэн өгч байсныг үнэлж дүгнэн харьцуулахад чиглэгдэнэ.

Түлхүүр үгс: хорих байгууллага, эрх зүйн зохицуулалт, хоригдол, хоригдлын хөдөлмөр эрхлэлт, хоригдолд боловсрол олгох, албан хаагч.

Abstract: The process of serving a sentence in prisons in Mongolia, the historical tradition of prisons, labor, professional orientation, socialization, form, organization, upbringing and education methods in prisons were studied in comparison with the relevant laws and results.

Keywords: Penitentiary institution, legal regulation, prisoner, employment of prisoners, prisoner education, official.

Нэг. Үндсэн хэсэг

Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж ирсэн хууль тогтоомжийн хөгжлийг 1921 оны Ардын хувьсгал ялж шинэ үеийн Эрүүгийн болон Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй үүсч хөгжсөн үеэс авч үзсэн ба хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх ажлын дундаас судалгааны зорилгын хүрээнд хоригдлын дунд сургалтыг зохион байгуулж ирсэн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлалыг судлаж үзье.

Монгол Улсын Хорих байгууллага нь 104 жилийн түүхийн хугацаанд хорих ял эдлүүлэх ажиллагааг тухайн үеийн хууль /1931, 1966, 1981, 1993, 1996,